



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2026 оны 03 сарын 23 өдөр

Дугаар A/13

Өмнөдэлгэр сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Байгалийн ухааны хичээлийн сургалтын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, сургалтын орчныг сайжруулах зорилгоор байгалийн ухааны туршилтын талбай, ногоон байгууламж байгуулах ажлын хүрээнд тендерийн техникийн тодорхойлолт боловсруулах, шаардлагатай материалуудыг бэлтгэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Д.Отгонжаргал (Биологийн багш)

Гишүүд: Г.Ганбаяр (Газарзүйн багш)

М.Гангаанай (Химийн багш)

Т.Батхүү (Физикийн багш)

Нарийн бичгийн дарга: Л.Шинэцэцэг (Эмч)

2. Ногоон байгууламж байгуулахтай холбоотой худалдан авах ажиллагаанд шаардлагатай баримт бичгийг бүрдүүлэн тухай бүр үнэлгээний хороонд хүргүүлж ажиллахыг ажлын хэсэг (Д.Отгонжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ



Д.ШИЖИРТУЯА